



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Богд сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/146/СТА-ТШЗ

Баянхонгор хот 2018 он



Тэргүүлэх аудитор:	Б.Мөнхбат
Утас: 99007576	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер:	Д.Цэцэгмаа
Утас: 88089024	Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn
Аудитор:	Б.Цэрэнчимэд
Утас: 88302569	Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
	Аудитаар алдаа зөрчил илрээгүй тул дараагийн аудитаар анхаарч авч үзэх асуудал байхгүй	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН.	10
3.1	Санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2	Санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
3.3	Мөнгөн гүйлгээний тайлан	12
3.4	Цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан	13
3.5	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	13

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БОГД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Д.ДАНДАР ТАНАА

2019.02.19 № 2/32

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Богд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Богд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Богд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа

D:\STA-2018\Богд сумын ИТХурал\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2515039

нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\STA-2018\Богд сумын ИТХурал\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Богд сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Дандарт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн удит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд сумын ИТХурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богд сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 01 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 01 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Богд сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Богд сумын ИТХурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Богд сумын ИТХурал нь “Нутгийн өөрийн удирдах ёсны байгууллагыг чадварлаг, нээлттэй, ил тод болгон төлөвшүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд тулгуурлан орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлж, ая тухтай ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлж, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Богд сумын ИТХурлын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Богд сумын ИТХурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох БНА-2019/146/СТА-ТШЗ

бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Богд сумын ИТХурлын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Богд сумын ИТХурал нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Санхүүгийн тооцох групп ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн "ACOLOUS" программ хангамж ашигладаг байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Богд сумын ИТХурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг

судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,0 хувиар сонгов.

Богд сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь 61445,1 мянган төгрөг бөгөөд түүний 2,0 хувь болох 1228,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэлээ.

Аудитын явцад алдаа зөрчил илрээгүй бөгөөд энэ талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөөгүй, акт, албан шаардлага тогтоогдоогүй болно.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй тул дараагийн аудитаар анхаарч авч үзэх асуудал байхгүй

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Богд сумын ИТХурлын 2018 оны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотойгоор 58866,7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Тайлант онд батлагдсан төсвийг 379,6 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлсэн байна. Зардлын бүлэг дотор хэтэрсэн хэмнэсэн зардлын шалтгаан тайлбарыг тусгайлан авч ажлын баримтад хавсаргасан болно.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Богд сумын ИТХурал нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 4 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж, зөвлөмж өгөөгүй, акт албан шаардлага тогтоогоогүй байна.

2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Богд сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Богд сумын ИТХурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд БНА-2019/146/СТА-ТШЗ

нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН.

3.1 Санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,382,000.00</u>	<u>2,651,900.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	2,382,000.00	2,651,900.00
354	Хангамжийн материал	2,382,000.00	2,651,900.00
35410	Бичиг хэргийн материал	1,332,500.00	1,353,400.00
35420	Аж ахуйн материал	1,049,500.00	1,298,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>413,530.38</u>	<u>2,279,591.70</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	413,530.38	2,279,591.70
392	Биет хөрөнгө	413,530.38	2,279,591.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	980,392.00	980,392.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-980,392.00	-980,392.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,647,870.00	5,697,870.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,598,097.94	-3,682,036.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,323,055.00	2,323,055.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,959,296.68	-2,059,296.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	416,070.00	416,070.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-416,070.00	-416,070.00
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,795,530.38</u>	<u>4,931,491.70</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,795,530.38</u>	<u>4,931,491.70</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,795,530.38	4,931,491.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,263,667.31	10,263,667.31
51101	Өмч: - төрийн	10,263,667.31	10,263,667.31
512	Хуримтлагдсан үр дүн	-7,468,136.93	-5,332,175.61
51210	Өмнөх үеийн үр дүн	-7,468,136.93	-7,468,136.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,135,961.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,795,530.38</u>	<u>4,931,491.70</u>

3.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	39,742,000.00	63,581,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,270,400.00

Богд сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,270,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,270,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	20,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,250,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,742,000.00	62,310,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	2,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,700,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,742,000.00	59,610,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,742,000.00	59,610,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	38,389,245.54	61,445,138.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,389,245.54	61,445,138.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,149,245.54	59,855,955.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,134,889.00	45,393,198.00
210101	Үндсэн цалин	27,434,889.00	41,793,198.00
210104	Урамшуулал	2,700,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,600,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,314,587.00	5,389,023.00
210201	Тэтгэврийн даатгал	3,314,587.00	5,389,023.00
2104	Хангамж, бараа материалын зардал	958,450.00	3,637,296.00
210401	Бичиг хэрэг	293,180.00	720,640.00
210402	Тээвэр, шатахуун	473,630.00	2,777,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	116,640.00	120,806.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	18,000.00
2105	Нормативт зардал	00.00	1,270,200.00
210502	Хоол, хүнс	00.00	1,270,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	743,500.00	00.00
210602	Тавилга	743,500.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	813,000.00	962,000.00
210702	Дотоод албан томилолт	813,000.00	962,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	395,000.00	2,100,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,000.00	2,100,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,789,819.54	1,103,938.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	985,000.00	920,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	472,350.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	332,469.54	183,938.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	240,000.00	1,589,183.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	240,000.00	440,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000.00	440,500.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,143,983.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,143,983.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	4,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,352,754.46	2,135,961.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,352,754.46	2,135,961.32

3.3 Мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	39,742,000.00	62,331,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	20,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	20,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	20,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	20,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,742,000.00	62,310,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	2,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,700,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,742,000.00	59,610,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,742,000.00	59,610,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	38,347,811.00	62,331,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,347,811.00	62,331,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,107,811.00	60,686,917.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,074,676.00	45,393,198.00
210101	Үндсэн цалин	27,374,676.00	41,793,474.00
210104	Урамшуулал	2,700,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,599,724.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,323,961.00	5,389,023.00
210201	Тэтгэврийн даатгал	3,323,961.00	3,871,545.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	324,194.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	301,070.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	79,294.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	812,920.00
2104	Хангамж, бараа материалын зардал	985,324.00	2,676,376.00
210401	Бичиг хэрэг	305,080.00	577,400.00
210402	Тээвэр, шатахуун	473,630.00	1,925,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	131,614.00	120,806.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	52,220.00
2105	Нормативт зардал	00.00	1,049,500.00
210502	Хоол, хүнс	00.00	1,049,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,058,500.00	800,000.00
210602	Тавилга	1,058,500.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	813,000.00	962,000.00
210702	Дотоод албан томилолт	813,000.00	962,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	395,000.00	2,815,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,000.00	2,815,300.00

Богд сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,457,350.00	1,601,520.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	985,000.00	1,361,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	472,350.00	239,720.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	240,000.00	1,644,183.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	240,000.00	495,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000.00	495,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,143,983.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,143,983.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	4,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,394,189.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,394,189.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,394,189.00	00.00

3.4 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,263,667.31	-7,468,136.93	2,795,530.38
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,263,667.31	-7,468,136.93	2,795,530.38
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,263,667.31	-7,468,136.93	2,795,530.38
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,263,667.31	-7,468,136.93	2,795,530.38
Тайлант үеийн үр дүн	00.00	2,135,961.32	2,135,961.32
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,263,667.31	-5,332,175.61	4,931,491.70

3.5 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,866,700.00	58,487,117.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,866,700.00	58,487,117.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,366,700.00	57,991,617.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,600,300.00	45,393,198.00
210101	Үндсэн цалин	42,000,300.00	41,793,474.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,600,000.00	3,599,724.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,472,000.00	5,389,023.00
210201	Тэтгэврийн даатгал	5,472,000.00	3,871,545.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	324,194.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	301,070.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	79,294.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	812,920.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,684,800.00	2,676,376.00
210401	Бичиг хэрэг	547,400.00	577,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,927,400.00	1,925,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	120,806.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	52,220.00
2105	Нормативт зардал	1,050,000.00	1,049,500.00
210502	Хоол, хүнс	1,050,000.00	1,049,500.00

Богд сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	800,000.00
210602	Тавилга	800,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	983,000.00	962,000.00
210702	Дотоод албан томилолт	983,000.00	962,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	120,000.00	120,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,000.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1656600.00	1601520.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	1,361,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	256,600.00	239,720.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500000.00	495500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	495,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	495,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,866,700.00	58,487,117.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	58,866,700.00	58,466,717.00
132001	Орон нутгийн төсвөөс	58,866,700.00	58,466,717.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	20,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	20,400.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	09	09
620001	Удирдах ажилтан	02	02
620002	Гүйцэтгэх ажилтан	07	07